

ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ БАРААНЫ МЭДҮҮЛГИЙГ НӨХӨН БИЧИХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг /цаашид “гаалийн мэдүүлэг” гэх/ нь барааг мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах, гадаад худалдааны барааны статистик мэдээлэл гаргах үндсэн баримт болно. Гаалийн мэдүүлэг нөхөн бичих, бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр илгээхэд гаалийн гадаад холболтын систем /цаашид CEPS гэх/-ийг ашиглана.
- 1.2. Гаалийн мэдүүлэг нь дараах 4 хэсгээс бүрдэнэ:
- I хэсэг- ерөнхий мэдээлэл (мэдүүлгийн 1-20 болон А хүснэгт);
- II хэсэг- бараа, тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл (21-43);
- III хэсэг-гаалийн тариф, татварын мэдээлэл (44-51);
- IV хэсэг-бичиг баримт, бусад мэдээлэл (52, С, D, E, F, G).
- 1.3. Гаалийн мэдүүлгийн маягт нь үндсэн болон нэмэлт гэсэн төрөлтэй байна. Гаалийн мэдүүлэг нь үндсэн нэг, нэмэлт хэд хэдэн мэдүүлгээс бүрдэж болно. Нэмэлт мэдүүлэг нь үндсэн мэдүүлгийн салшгүй хэсэг байна.
- 1.4. Гаалийн мэдүүлгийг монгол хэл дээр үйлдэнэ.
- 1.5. Гаалийн мэдүүлгийг батлагдсан маягтын дагуу нөхөн бичнэ.
- 1.6. Гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон ажлын цагт багтаан гаалийн мэдүүлгийг хүлээн авна.
- 1.7. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад дараах этгээд мэдүүлнэ:
- 1.7.1. бараа илгээх, эсхүл хүлээн авах Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага өөрөө, эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу түүний итгэмжлэгдсэн этгээд;
- 1.7.2. гаалийн хилээр нэвтрэх зорчигч, бараа хүлээн авах, илгээх хувь хүн;
- 1.7.3. энэ зааврын 1.7.1, 1.7.2 дахь заалтад заасан этгээдтэй байгуулсан гаалийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр гаалийн зуучлагч;
- 1.7.4. шаардлагатай тохиолдолд тээвэрлэгч, гаалийн түр агуулахын болон баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зэрэг этгээд.
- 1.8. Гаалийн хилээр нэвтрүүлж байгаа дараах бараанд гаалийн мэдүүлэг нөхөн бичихгүй:
- 1.8.1. Гаалийн тухай хуулийн 220.1 дэх хэсэгт заасан дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа;
- 1.8.2. улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журамд заасан маягтаар гаалийн бүрдүүлэлт хийх бараа;
- 1.8.3. гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журамд маягтаар гаалийн бүрдүүлэлт хийхээр заасан бараа.
- 1.9. Гаалийн хилээр нэвтрүүлэх дараах бараанд зөвхөн үндсэн мэдүүлэг бичнэ:
- 1.9.1. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх бараа;
- 1.9.2. автомашин, чиргүүл;
- 1.9.3. өөрөө явагч машин механизм, дугуйт трактор.
- 1.10. Цахилгаан, дулааны эрчим хүч, хий, уур, ус гэх мэт тусгай хоолой, шугамаар тээвэрлэгдэх барааны тоо хэмжээг нь нарийвчлан хянах баталгаат тоолуурын үндсэн дээр холбогдох бичиг баримтуудыг үндэслэн сард нэгээс доошгүй удаа мэдүүлнэ.
- 1.11. Гаалийн баталгаат бүсэд байршуулсан барааг өөр гаалийн баталгаат бүсэд шилжүүлэхэд тухайн барааг хадгалж буй гаалийн баталгаат бүсэд хяналт тавьж байгаа гаалийн байгууллагад мэдүүлнэ.
- 1.12. Нэг ачилтаар ирсэн боловч өөр өөр баталгаат бүсэд орох бараанд тусад нь мэдүүлэг бичнэ.
- 1.13. Татваргүй барааны дэлгүүрт худалдагдсан барааг барааны нэр, марк, зориулалт, барааны ангиллын кодоор нэгтгэж мэдүүлнэ.

- 1.14.Тээврийн бичиг баримтад заасан хүрэх өртөөнд буух барааг тухайн өртөөг харъяалах гаалийн байгууллагад мэдүүлнэ.
- 1.15.Энэ зааврын 1.14 дэх хэсэгт заасан гаалийн байгууллагыг солих шаардлагатай бол гаалийн удирдах төв байгууллагаас зөвшөөрөл авна.
- 1.16.Гаалийн бүрдүүлэлтийн нэг горимд байрших нэг ачилтын бараанд гаалийн нэг мэдүүлэг бичнэ. Нэг ачилт гэдэгт нэг илгээгчээс нэг хүлээн авагчид очих, нэг өдөр ачигдсан, тээврийн нэг бичиг баримттай барааг ойлгоно.
- 1.17.Нэмэлт мэдүүлэгт бичигдэх барааны гаалийн бүрдүүлэлтийн горим болон горимын код нь үндсэн мэдүүлэгт бичигдсэн барааны горим болон горимын кодтой ижил байна. Горим өөр бол тусад нь мэдүүлэг бичнэ.
- 1.18.Нэг илгээгчээс нэг хүлээн авагчид илгээсэн тус тусдаа тээврийн бичиг баримт бүхий барааны оноосон нэр, ангиллын код, гарал үүсэл нь ижил бөгөөд нэг өдөр хүлээн авч байгаа, эсхүл нэг өдөр илгээж байгаа тохиолдолд нэг ачилт гэж үзэж, багцалж гаалийн нэг мэдүүлгээр бүрдүүлэлт хийж болно.
- Багцалж мэдүүлэх тохиолдолд энэ тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан гаалийн мэдүүлгийн хавсралтыг бичнэ. Энэ хавсралт нь гаалийн мэдүүлгийн салшгүй хэсэг бөгөөд үндсэн мэдүүлгийн дугаартай ижил дугаартай байна.
- 1.19.Нэг тээврийн хэрэгсэлд иж бүрдлээр нь тээвэрлэх боломжгүйгээс эд анги, бүрдэл хэсгээр нь салгаж тээвэрлэсэн боловч технологийн горимын шаардлагын дагуу иж бүрдэл болж ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмыг нэг ачилтад хамааруулж болно.
- 1.20.Энэ зааврын 1.19 дахь хэсэгт заасан барааг гаалийн хууль тогтоомж, журамд заасан хугацааг баримтлан, угсрах, иж бүрдэл болгох ажлыг гаалийн хяналтын бүс, тээврийн байгууллага, бараа эзэмшигчийн мэдлийн байр, агуулахад гүйцэтгэхийг зөвшөөрнө. Энэ тохиолдолд хамгийн сүүлийн ачилт ирсний дараа нэг мэдүүлэг бичих бөгөөд бүрдэлд хамаарахгүй бараанд тусад нь гаалийн мэдүүлэг бичнэ.
- 1.21.Нэг тээврийн хэрэгсэлд олон нэр төрлийн бараа ачигдсан тохиолдолд мэдүүлэгчийн хүсэлтээр тухайн ачилтад байгаа, БТКУС-ийн нэг зүйлд хамрагдах барааг өндөр тарифтай нэг бараагаар нь төлөөлүүлэн мэдүүлж болно. Энэ тохиолдолд бусад барааны нэр, тоо хэмжээ, үнийг тусгасан баримтыг гаалийн мэдүүлэгт хавсаргана.
- 1.22.Мэдүүлгийн огноог араб тоогоор он, сар, өдөр гэсэн дарааллаар тэмдэглэнэ.
- 1.23.Гаалийн мэдүүлэгт бичигдсэн мэдээлэл нь гаалийн бүрдүүлэлтийн горимын агуулгад нийцсэн, бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримтын мэдээлэлтэй тохирсон байна.
- 1.24.Мэдүүлэгч мэдүүлгийн маягтын хүснэгтүүдийг бараа мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтыг үндэслэн бүрэн гүйцэд, үнэн зөв бичиж, бичиг баримтыг гаалийн байгууллагад шилжүүлнэ. Мэдүүлэгч шаардлагатай бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон ажлын цагт гаргаж өгнө.
- 1.25. Мэдүүлэгч барааг мэдээллийн сүлжээгээр мэдүүлж, Гаалийн тухай хуулийн 60.3.1-60.3.5 дахь заалт, 75.1 дэх хэсэгт заасан бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд мэдээллийн сүлжээгээр ирүүлж болно.
- 1.26.Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн үнийг тодорхойлж, гаалийн байгууллагад мэдүүлнэ.
- 1.27.Мэдүүлэгч гаалийн үнийг тодорхойлсон бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.
- 1.28.Гаалийн удирдах төв байгууллагын холбогдох нэгж нь энэ зааврын 3, 4 дүгээр хавсралтад заасан (*) тэмдэглэгээтэй кодыг шаардлагатай тохиолдолд програмд идэвхжүүлж, гаалийн хяналт, бүрдүүлэлтэд ашиглаж болно.
- 1.29.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь бүрдүүлэлтийн дараах шалгалтаар илэрсэн зөрчилд холбогдох барааг шалгалтын актыг үндэслэн гаальд мэдүүлнэ.
- 1.30.Гаалийн удирдах төв байгууллагын гаалийн зөрчлийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн улсын байцаагчийн илрүүлсэн зөрчилд холбогдох барааны мэдүүлэг нөхөн бичихдээ энэ зааврын 12 дугаар хавсралтаар батлагдсан “Хэлцлийн код”-оос “370”, татваргүй барааны дэлгүүрт худалдагдсан гадаадын болон монголын барааны гаалийн мэдүүлэг нөхөн бичихэд “390”, “391” кодыг сонгоно.
- 1.31.Мэдүүлэгч нөхөн бичсэн мэдүүлгийг гаалийн байгууллагад ажлын 5 хүртэлх хоногийн хугацаанд сүлжээгээр илгээнэ.
- 1.32.Энэ зааврын 1.31 дэх хэсэгт заасан хугацаанд мэдүүлгийн бичлэгийг мэдүүлгийн програмаас илгээгээгүй бол бичлэг устгагдана.

Хоёр. Гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичих

Хүснэгт	Хүснэгтийн Нэр	Тайлбар
1	Бүрдүүлэлтийн горим	<p>Нэгдүгээр хүснэгтийн арын хэсэгт бүрдүүлэлтийн горимын кодыг бичих бөгөөд хүснэгтийн эхний хэсэгт тухайн барааг гаалийн хилээр нэвтрүүлж байгаа ялгаанаас хамааран:</p> <ul style="list-style-type: none"> -гаалийн хилээр оруулах барааг – “ОР” -гаалийн хилээр гаргах барааг – “ГА” -барааг шилжүүлэн ачих бол – “ШИ” -барааг устгахад – “УС” -барааг хүлээн авахаас татгалзах – “ТА” <p>гэсэн 2 үсэгт тэмдэглэгээ мэдүүлгийн програмаас бичигдэнэ.</p> <p>Гаалийн баталгаат бүсүүдээс 401, 402, 403, 507 горимын кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд горим тус бүрийн ард “1” гэсэн тоог бичнэ. /ГЕГ-ын даргын 2019 оны А/250 дугаар тушаалаар "507"-г нэмсэн/</p>
2	Илгээгч/ экспортлогч Per№ Утас№	<p>Үндсэн мэдүүлэгт барааг илгээгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр, хаяг, утас, регистр аж ахуйн нэгжийн гэрчилгээний бүртгэлийн дугаарыг бүрэн гүйцэд бичнэ.</p> <p>ААН-ийн нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бичиж баталгаажуулсаны дагуу бичнэ.</p> <p>Импортын барааг илгээгч, экспортын барааг хүлээн авагч гадаадын ААН, байгууллага, иргэний нэр, хаягийг кирилл үсгэнд хөрвүүлэх шаардлагагүй бөгөөд, эхний үсгийг томоор бусад үсгийг жижгээр бичнэ.</p>
3	Нэмэлт №	<p>Тухайн мэдүүлгийн хуудасны дарааллын дугаарыг эхний хэсэгт, нийт бичсэн мэдүүлгийн хуудас (нэмэлт мэдүүлгийн хамт)-ны тоог дараагийн хэсэгт бичнэ.</p> <p>Гаалийн нэг мэдүүлгээр багцлан мэдүүлж байгаа тохиолдолд гуравдугаар хүснэгтийн арын хэсэгт “Б” тэмдэглэгээ мэдүүлгийн програмаас бичигдэнэ.</p>

4	<p>Хүлээн авагч/ импортлогч</p> <p>Per№</p> <p>Утас№</p>	<p>Бараа хүлээн авагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр, хаяг, утас, регистрийн дугаар, аж ахуйн нэгжийн гэрчилгээний бүртгэлийн дугаарыг бүрэн гүйцэд бичнэ.</p> <p>ААН-ийн нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бичиж баталгаажуулсаны дагуу бичнэ.</p> <p>Импортын барааг илгээгч, экспортын барааг хүлээн авагч гадаадын ААН, байгууллага, иргэний нэр, хаягийг кирилл үсгэнд хөрвүүлэх шаардлагагүй ба, эхний үсгийг томоор бусад үсгийг жижгээр бичнэ.</p> <p>Гаалийн бүрдүүлэлтийн горимын 314 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд татваргүй барааны дэлгүүрээр тухайн сард үйлчлүүлсэн дипломат эрх ямба дархан эрх эдлэх байгууллага, албан тушаалтан, зорчигчийн тоог бичнэ.</p> <p>Тухайлбал:</p> <p>Гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байрлах дэлгүүрт борлуулсан барааг мэдүүлж байгаа бол дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтан-20,</p> <p>Хилийн боомтод байрлах дэлгүүрт борлуулсан барааг мэдүүлж байгаа бол зорчигч -10 гэх мэт</p>
5	Санхүүгийн хувьд хариуцагч байгууллага	Гадаад худалдааны төлбөр тооцоо хийсэн банкны нэр, дансны дугаар бичнэ.
6	Бүгд нэр төрөл	Нэг ачилтад хамрагдах барааны нэр төрлийн тоо.
7	Бараа нийлүүлэх нөхцөл	Эхний хэсэгт Инкотермсийн нэр томъёог, дараагийн хэсэгт бараа нийлүүлэх газар, боомтын нэрийг хэлцэлд зааснаар бичнэ.

8	Хэлцэл	<p>Хэлцлийн төрлийн кодыг бичнэ. Хэлцлийн төрлийн кодыг бүрдүүлэлтийн горим болон гарал үүслийн улстай уялдуулан сонгож бичнэ.</p> <p>Тухайлбал:</p> <p><u>-реэксспорт</u> – өмнө нь импортод бүртгэгдэж байсан гадаадын барааны экспорт. Үүнд:гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байсан гадаадын бараа (гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа гадаадын бараа гаалийн тухай хуулийн дагуу монголын бараанд хамаарах ч, гарал үүсэл нь гадаадын бараа тул гадаад худалдааны барааны статистикийг эрхлэн гаргах аргачлалын дагуу реэкспортод тооцогдоно), гаалийн баталгаат бүсэд байршуулсан гадаадын бараа, гаалийн нутаг дэвсгэрт боловсруулалт хийгдсэн гадаадын барааг буцаан гаргах хамаарна. Реэкспортын барааны гарал үүслийн улс нь гадаад улс байна.</p> <p><u>-реимпорт</u> – өмнө нь экспортод бүртгэгдсэн монголын барааны импорт. Үүнд: хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын бараа (хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын бараа гарал үүслийн хувьд монголын бараа хэвээр байгаа тохиолдолд статистикийн хувьд реимпортод хамаарна) болон боловсруулах горимд байршуулж, хилийн чанадад гаргасан монголын барааг буцаан оруулах хамаарна. Реимпортын барааны гарал үүслийн улс нь зөвхөн монгол байна.</p> <p><u>-боловсруулалтын бараа</u> – Бараанд боловсруулалт хийсний дараа барааны гарал үүслийн улс нь өөрчлөгдсөн бол “боловсруулалтын бараа” хэлцлийн код сонгох ба гарал үүслийн улс нь хэвээрээ бол барааны урсгалаас хамааран реэксспорт, реимпортын аль нэгийг сонгоно.</p>
9	Мэдүүлэгч байгууллага, Per№ мэдүүлэгч Утас	<p>Барааг гаалийн байгууллагад мэдүүлж буй зуучлагч байгууллагын нэр, хаяг, утас, регистрийн дугаарыг бичнэ. Хүснэгтийн доод хэсэгт гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үнэмлэхийн дугаар системээс бичигдэж, хүснэгтэн дэх мэдээлэл баталгаажигдана.</p> <p>Гаалийн зуучлагчаар дамжуулаагүй тохиолдолд барааг гаалийн байгууллагад мэдүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, утас, регистрийн дугаарыг бичнэ.</p> <p>Энэ тохиолдолд хүлээн авагч нь мэдүүлэгч өөрөө байх ба хүснэгтийн доод хэсэгт мэдүүлэг нөхөн бичсэн тухайн байгууллагын ажилтны бүртгэлийн дугаар системээс бичигдэж, хүснэгтэн дэх мэдээлэл баталгаажигдана.</p>
10	Илгээгч улсын код, нэр	<p>Тээврийн бичиг баримтад бичигдсэн, барааг илгээх улсын код, нэрийг бичнэ.</p> <p>Холимог тээвэр болон хэд хэдэн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн тохиолдолд эхний тээврийн бичиг баримтад бичигдсэн илгээх улсын код, нэрийг бичнэ.</p> <p>Гаалийн баталгаат бүс, гаалийн чөлөөт бүсийн хооронд бараа шилжүүлж байгаа тохиолдолд илгээгч улс нь барааг гаалийн хилээр нэвтрүүлэх үед гаальд мэдүүлсэн илгээгч улс байна.</p> <p>Гаалийн бүрдүүлэлтийн горимын 314 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд илгээгч улс нь Монгол улс байна.</p>

11	Гэрээлэгч улсын код, нэр	<p>Бараа нийлүүлэхээр гэрээ байгуулсан гадаад гэрээлэгчийн харъяалагдах улсын код, нэрийг бичнэ.</p> <p>Гаалийн баталгаат бүс, гаалийн чөлөөт бүсийн хооронд бараа шилжүүлж байгаа тохиолдолд гэрээлэгч улс нь барааг гаалийн хилээр нэвтрүүлэх үед гаальд мэдүүлсэн гэрээлэгч улс байна.</p>
12	Хүлээн авагч улсын код, нэр	<p>Тээврийн бичиг баримтад бичигдсэн, барааг хүлээн авч байгаа улсын код, нэрийг бичнэ.</p> <p>Гаалийн баталгаат бүс, гаалийн чөлөөт бүсийн хооронд бараа шилжүүлж байгаа тохиолдолд хүлээн авагч улс нь барааг гаалийн хилээр нэвтрүүлэх үед гаальд мэдүүлсэн хүлээн авагч улс байна.</p>
13	Хандивлагч улсын код, нэр	<p>Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, засгийн газрын болон засгийн газрын бус зээлийн барааг олгож байгаа улс, олон улсын байгууллагын код, нэрийг бичнэ.</p>
14	Илгээх үеийн тээврийн хэрэгсэл	<p>Эхний хэсэгт бараа илгээх үеийн тээврийн хэрэгслийн харъяалагдах улсын код, дунд хэсэгт тээврийн төрлийн код, сүүлийн хэсэгт тээврийн хэрэгслийн дугаарыг тус тус бичнэ.</p> <p>Холимог тээврээр болон хэд хэдэн тээврийн хэрэгсэл дамжин тээвэрлэсэн тохиолдолд 14, 15 дугаар хүснэгтийн үзүүлэлтүүд өөр өөр байна.</p> <p>Гаалийн нэг мэдүүлгээр багцалж мэдүүлэх тохиолдолд эхний хэсэгт барааг илгээх үеийн тээврийн хэрэгслийн харъяалагдах улсын код, дунд хэсэгт тээврийн төрлийн код, дараагийн хэсэгт тээврийн хэрэгслийн нийт тоог тус тус бичнэ. Тээврийн хэрэгсэл бүрийн дугаарыг гаалийн мэдүүлгийн хавсралтад бичнэ.</p>
15	Хил дээрх тээврийн хэрэгсэл	<p>Эхний хэсэгт Монгол улсын хилээр бараа нэвтрүүлэх үеийн тээврийн хэрэгслийн харъяалагдах улсын код, дунд хэсэгт тээврийн төрлийн код, сүүлийн хэсэгт тээврийн хэрэгслийн дугаарыг тус тус бичнэ.</p> <p>Гаалийн нэг мэдүүлгээр багцалж мэдүүлэх тохиолдолд эхний хэсэгт Монгол улсын хилээр бараа нэвтрүүлэх үеийн тээврийн хэрэгслийн харъяалагдах улсын код, дунд хэсэгт тээврийн төрлийн код, дараагийн хэсэгт тээврийн хэрэгслийн нийт тоог тус тус бичнэ.</p> <p>Тээврийн хэрэгсэл бүрийн дугаарыг гаалийн мэдүүлгийн хавсралтад бичнэ.</p> <p>Гаалийн бүрдүүлэлтийн горимын 314 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд "00" тэмдэглэгээг бичнэ.</p>
16	Чингэлэг №	<p>Бараа чингэлэгт ачигдсан бол чингэлгийн үсгэн тэмдэглэгээ болон дугаарыг, чингэлэгт ачигдаагүй бол "00" тэмдэглэгээг бичнэ.</p>
17	Ачих, буулгах газар	<p>Барааг ачих, буулгах аймаг, хот, газар, өртөөний кодыг эхний хэсэгт, нэрийг дараагийн хэсэгт бичнэ.</p> <p>Гаалийн хилээр оруулах барааны хувьд хилээр тээвэрлэж оруулсан тээврийн хэрэгслээс барааг буулгасан газрын кодыг, гаалийн хилээр гаргах барааны хувьд гаалийн хилээр гаргах тээврийн хэрэгсэлд барааг ачсан газрын кодыг бичнэ.</p>

18	Барааны байршил	Барааг гаальд мэдүүлэх үед тухайн бараа байрлаж буй гаалийн хяналтын бүсийн код эсхүл гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсийн кодыг эхний хэсэгт, нэрийг дараагийн хэсэгт бичнэ. Хяналтын бүсгүй газар, өртөөнд хяналт шалгалт хийх бол өртөөний код, нэрийг бичиж болно.
19	Валютын код, нийт дүн	<p>Эхний хэсэгт хэлцлийн дагуу төлбөр хийсэн валютын код, дараагийн хэсэгт тухайн валютаар илэрхийлэгдсэн нийт үнийн дүн буюу тухайн ачилтад хамрагдах бүх барааны нийт үнийн дүнг бичнэ.</p> <p>Хэрвээ хэлцэлээр барааны төлбөр олон төрлийн валютаар хийгдсэн бол хамгийн их үнийн дүнтэй валютаар бусдыг нь илэрхийлж бичнэ.</p> <p>Хэлцэл нь төгрөгт хөрвөдөггүй валютаар хийгдсэн бол тухайн валютыг ам.долларт хөрвүүлэн бичнэ. Энэ тохиолдолд барааны үнийн нэхэмжлэх дээр өөр валютад хөрвүүлсэн тухай болон ханшийн талаар тэмдэглэл хийнэ.</p>
20	Ханш	Гаалийн байгууллагад мэдүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, 19 дүгээр хүснэгтэд бичигдсэн валютын төгрөгтэй харьцах ханшийг бичнэ.
		<p>Барааны нэр, төрлийг хэлцэлд зааснаар тодорхой бичнэ.</p> <p>Энэ хүснэгтэд барааны онцлог шинж, савлагаа, агууламж, зориулалт гэх мэт тухайн барааг тодорхойлох үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй бичнэ.</p> <p>Мэдүүлгийн програм дахь барааны нэр хэсгийн 5 талбарт мэдээллийг дараах дарааллаар оруулна:</p> <p>-“Барааны нэр” талбарт барааны ерөнхий нэрийг бичиж таслал тавин, тухайн барааг тодотгосон онцлог шинжийг бичнэ. Тухайлбал: Тамхи, янжуур, шүүлтүүртэй.</p> <p>-“Марк” талбарт барааны нэр, стандартыг бичнэ. Барааны нэрийг хэлцэлд туссан байдлаар нь бичих бөгөөд гадаад нэрийг кирилл үсгэнд хөрвүүлэхгүй. Эхний үсгийг томоор бусад үсгийг жижгээр бичнэ.</p> <p>Тухайлбал: Esse</p> <p>Стандартын үсгэн тэмдэглэгээг том үсгээр бичнэ.</p> <p>-“Зориулалт” талбарт барааны агууламж, онцлог шинж, чанарын тодорхойлолт, савлагааг бичнэ. Тухайлбал: 1хайрцаг*50блок*10ж/х*20ш, бохь 20мг, ник 1.6мг</p> <p>-“Үйлдвэрлэгч” талбарт тухайн барааг үйлдвэрлэсэн компанийн нэрийг бичнэ. Жишээ нь: суудлын автомашины хувьд Toyota; Nissan гэх мэт; телевизор Sony, LG гэх мэт бичнэ.</p> <p>-“Үйлдвэрлэсэн он” талбарт тухайн барааг үйлдвэрлэсэн оныг бичнэ.</p> <p>Гаалийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад заасан тээврийн хэрэгсэл болон БТКУС-ийн зүйл 84.29-д хамаарах хүнд машин механизмын хувьд мэдүүлгийн програмын барааны бичиглэлийн талбарт мэдээллийг дараах байдлаар бичнэ:</p> <p>-“Оноосон нэр” талбарт тээврийн хэрэгслийн төрөл, тээврийн хэрэгслийн нэр, кузовын төрлийг сонгоно.</p> <p>Жишээ нь:</p>

21	Барааны нэр, төрөл	<p>тээврийн хэрэгслийн төрөл: суудлын , ачааны г.м</p> <p>тээврийн хэрэгслийн нэр: Toyota, Nissan г.м.</p> <p>модель: Rav4 г.м.</p> <p>кузовын төрөл: АСА36W г.м.</p> <p>-“Марк артикул” талбарт арлын дугаарыг бичиж, хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж /1800сс/-ийг, кропны төрөл /transmission:автомат, механик г. м./, хөтлөгчийн төрөл /drivetrain: AWD, 4WD г. м./-ийг сонгоно.</p> <p>-“Үйлдвэрлэсэн компани” талбарт тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн нэр /Toyota, Nissan г. м./, хөдөлгүүрийн төрөл /бензин, дизель г. м./ -ийг сонгоно.</p> <p>-“Үйлдвэрлэсэн он” гэсэн талбарт тухайн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэсэн он, сарын хооронд цэг тавьж, бичнэ. /жишээ нь: xxxx.xx буюу 2014.05 г.м./;</p> <p>-“Зориулалт” талбарт автомашины гүйлтийг км-ээр илэрхийлэн бичиж, гадна өнгийг сонгоно;</p> <p>- - Бусад мэдээлэл талбарт тухайн тээврийн хэрэгслийн үнэд нөлөөлөх үзүүлэлтийг бичнэ.</p> <p>- Жишээ нь: Автобусны суудлын тоо болон зорчигчийн багтаамж, автокраны сумны урт, даац, ачааны автомашины даац, бүх жин, хүчин чадал, зориулалт г.м</p> <p>- “Лавлах сан”-д тээврийн хэрэгслийн нэр /make/, модель, кузовын төрөл, хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж, кропны төрөл /transmission/, хөтлөгчийн төрөл /drivetrain/, хөдөлгүүрийн төрөл /engine type/, үйлдвэрлэсэн он, гүйлт, гадна өнгө зэрэг үзүүлэлтийг олон улсын худалдаанд хэрэглэгддэг нийтлэг бичиглэлээр тусгана.</p> <p>- “Лавлах сан”-д тээврийн хэрэгслийн бичиглэлийг шинээр үүсгэх асуудлыг тухай бүр гаалийн удирдах төв байгууллагын холбогдох нэгжид илгээж шийдвэрлүүлнэ.</p> <p>-“Лабораторын дүгнэлт” талбарт Мэдүүлгийн бараа тус бүр дээр гаалийн төв лабораторын дүгнэлтийн дугаарыг татахад "гэрээ бүртгэлийн нэгдсэн системийн гэрээний дугаар", "гэрээ бүртгэлийн нэгдсэн системээс тухайн гэрээний харгалзах барааны дугаар" талбарууд програмаас бөглөгдөнө" <i>Энэ хэсгийг Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/346 дугаар тушаалаар нэмсэн.</i></p>
22	Д/Д	Эхний хэсэгт тухайн барааны дарааллын дугаар, дараагийн хэсэгт барааны нийт нэр төрлийн тоог бичнэ.
23	Барааны код	Барааны ангиллын кодыг Уялдуулсан системийн дагуу 8 оронгийн түвшинд бичнэ.
24	Гарал үүслийн улсын код, нэр	Барааны гарал үүслийн улсын код, нэрийг бичнэ.

25	Хэмжих нэгж, тоо хэмжээ /хэлцэлд заасан/	Хэлцэлд заасан хэмжих нэгжийг эхний хэсэгт, тоо хэмжээг дараагийн хэсэгт бичнэ. Гаалийн нэг мэдүүлгээр багцалж мэдүүлэх тохиолдолд тухайн мэдүүлэгт хамрагдах бүх тээврийн хэрэгсэлд ачигдсан барааны нийт тоо хэмжээг бичнэ.
26	Хэмжих нэгж, тоо хэмжээ /ангиллын/	Уялдуулсан системийн хэмжих нэгжийг эхний хэсэгт, тоо хэмжээг дараагийн хэсэгт бичнэ. Ангиллын хэмжих нэгж хэлцлийнхээс өөр байгаа тохиолдолд ангиллын тоо хэмжээг тооцож гаргахдаа хэлцлийн хэмжих нэгжийн тоон утгыг ангиллын хэмжих нэгжээр илэрхийлж, хэлцлийн тоо хэмжээгээр үржүүлнэ. <u>Жишээ 1:</u> Хэлцэлд 500 хайрцаг шар айраг (24ш*0.33л) гэж тусгагджээ. Ангиллын дагуу шар айрагны хэмжих нэгж “литр” байдаг. “Хайрцаг” гэсэн хэлцлийн хэмжих нэгжийг ангиллын хэмжих нэгж “литр”-ээр илэрхийлбэл: $1 \text{ хайрцаг} = 24\text{ш} * 0.33\text{л} = 7.92\text{л}$ болно. Тэгвэл ангиллын тоо хэмжээ нь: $7,92 * 500 = 3960\text{л}$ болно. <u>Жишээ 2:</u> Хэлцэлд 30 хайрцаг янжуур тамхи (50блок*20ж/хайрцаг*20ш) гэж үзвэл, БТКУС -ын дагуу ангиллын хэмжих нэгж нь мян.ш байна. $1 \text{ хайрцаг} = 50 * 10 * 20 = 10000\text{ш}$ Ангиллын хэмжих нэгж нь: $10000 * 30 = 300000\text{ш}$ буюу 300мян.ш болно. Гаалийн нэг мэдүүлгээр багцалж мэдүүлэх тохиолдолд тухайн мэдүүлэгт хамрагдах бүх тээврийн хэрэгсэлд ачигдсан барааны нийт тоо хэмжээг бичнэ.
27	Баглаа боодол	Эхний хэсэгт тухайн барааны баглаа боодлын код, дараагийн хэсэгт тоо ширхэгийг бичнэ. Баглаа боодлын код 01, 02 /задгай/ байх тохиолдолд арын хэсэгт “00” гэж бичнэ. Гаалийн нэг мэдүүлгээр багцалж мэдүүлэх тохиолдолд тухайн мэдүүлэгт хамрагдах бүх тээврийн хэрэгсэлд ачигдсан барааны баглаа боодлын нийт тоог бичнэ.
28	Бохир жин (кг)	Барааны бохир жинг кг-аар илэрхийлнэ. Хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн зориулалттай баглаа боодлын жин нь бохир жинд орно. Гаалийн нэг мэдүүлгээр багцалж мэдүүлэх тохиолдолд тухайн мэдүүлэгт хамрагдах бүх тээврийн хэрэгсэлд ачигдсан барааны нийт бохир жинг бичнэ.

29	Суурь нэгж үнэ	<p>Уялдуулсан системийн хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн суурь нэгж үнийг бичнэ.</p> <p>Хэлцэлд өөр хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн бол хэлцэл, эсхүл үнийн нэхэмжлэх дэх тухайн барааны нийт үнийн дүнг 26 дугаар хүснэгтийн ангиллын тоо хэмжээнд хувааж ангиллын хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн суурь нэгж үнийг гаргана.</p> <p>Суурь нэгж үнэ нь хэлцэлд заагдсан /19 дүгээр хүснэгтэн дэх/ валютаар илэрхийлэгдэнэ.</p> <p>Жишээ 1:</p> <table border="1" data-bbox="466 497 1038 701"> <thead> <tr> <th>Барааны нэр</th> <th>Хэмжих нэгж</th> <th>тоо</th> <th>нэгж үнэ</th> <th>Нийт үнэ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шар айраг</td> <td>Хайрцаг /24ш*0.33л/</td> <td>500</td> <td>12\$</td> <td>6000\$</td> </tr> </tbody> </table> <p>26-р хүснэгтийн жишээнд бодсоноор ангиллын тоо хэмжээ нь: 3960 л бол</p> <p>Суурь нэгж үнэ нь: $6000\\$/3960=1.52\\$/1\text{л шар айрагны үнэ/}$ болно.</p> <p>Жишээ 2:</p> <table border="1" data-bbox="466 925 1048 1128"> <thead> <tr> <th>Барааны нэр</th> <th>Хэмжих нэгж</th> <th>тоо</th> <th>Нэгж үнэ</th> <th>Нийт үнэ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>янжуур тамхи Kent</td> <td>Хайрцаг (50*10*20)</td> <td>30</td> <td>250\$</td> <td>7500\$</td> </tr> </tbody> </table> <p>26-р хүснэгтийн жишээ 2-д бодсоноор ангиллын тоо хэмжээ нь: 300 мян.ш бол</p> <p>Суурь нэгж үнэ нь: $7500\\$/300=25\\$/1\text{мян.ш янжуур тамхины үнэ/}$ болно.</p>	Барааны нэр	Хэмжих нэгж	тоо	нэгж үнэ	Нийт үнэ	Шар айраг	Хайрцаг /24ш*0.33л/	500	12\$	6000\$	Барааны нэр	Хэмжих нэгж	тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	янжуур тамхи Kent	Хайрцаг (50*10*20)	30	250\$	7500\$
Барааны нэр	Хэмжих нэгж	тоо	нэгж үнэ	Нийт үнэ																		
Шар айраг	Хайрцаг /24ш*0.33л/	500	12\$	6000\$																		
Барааны нэр	Хэмжих нэгж	тоо	Нэгж үнэ	Нийт үнэ																		
янжуур тамхи Kent	Хайрцаг (50*10*20)	30	250\$	7500\$																		

30	Тээврийн зардал	<p>Бараа импортлоход Монгол улсын хилийн боомт хүртэл, экспортлоход улсын хил хүртэл тээвэрлэх, ачих буулгах, шилжүүлэн ачихад гарах зардлын тухайн бараанд ногдох дүнг бичнэ.</p> <p>Тайлбар: Мэдүүлгийн 30 дугаар хүснэгтэд хэлцлийн үнэ дээр нэмэгдэж тооцогдох тээврийн зардлыг тухайн барааны нийт хэмжээнд ногдох хэсгийг хуваарилж тавих бөгөөд эдгээр зардлууд нь 7 дугаар хүснэгтэд бичигдсэн бараа нийлүүлэх нөхцөлөөс хамааран хэлцлийн үнэд шингээгүй, нэмэгдвэл зохих зардал байна. Нэмэгдвэл зохих тээврийн зардал нь 29 дүгээр хүснэгтэд тавигдах суурь нэгж үнэтэй ижил валютаар илэрхийлэгдсэн байх ёстой бөгөөд хэрэв өөр валютаар байвал хөрвүүлнэ.</p> <p>Нэг ачилтаар хэд хэдэн төрлийн барааг улсын хилээр оруулж ирсэн тохиолдолд хэлцлийн үнэ дээр нэмэгдэх зардлыг бараа болгонд хуваарилахдаа нийт ачилтын цэвэр жинд тухайн барааны ногдох жинг харьцуулах бөгөөд ийнхүү жинг харьцуулан зардлыг хуваарилах боломжгүй бол эзлэхүүн, эсхүл үнийн дүнг харгалзан зардлыг хуваарилж болно.</p> <p>Худалдаж авсан чингэлгээр бараа тээвэрлэсэн нөхцөлд чингэлэгт тээврийн зардлыг хуваарилж тооцохгүй.</p> <p>Энэ хүснэгтийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн IV, V бүлэгт нийцүүлэн нөхөн бичнэ.</p>
31	Даатгал	<p>Бараа импортлоход Монгол улсын хилийн боомт хүртэл, экспортлоход улсын хил хүртэл гарах даатгалын хураамжийн дүнг бичнэ.</p> <p>31 дүгээр хүснэгтэд 7 дугаар хүснэгтэд бичигдсэн бараа нийлүүлэх нөхцөлөөс хамааран хэлцлийн үнэд шингээгүй даатгалын зардлыг бичнэ. Нэмэгдвэл зохих даатгалын зардлыг 29 дүгээр хүснэгтийн суурь нэгж үнэтэй ижил валютаар илэрхийлнэ. Өөр валютаар байвал хөрвүүлэн тооцно. Тухайн бараанд ногдох даатгалын зардлыг тооцохдоо нийт үнийн дүнд эзлэх хувиар бодно.</p>
32	Нэмэгдэх зардал	<p>Хэлцлийн үнэд нэмэгдвэл зохих тээвэрлэлт, даатгалын зардлаас бусад, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн IV, V бүлэгт заасан бусад нэмэгдэх зардлын дүнг бичнэ.</p> <p>Нэмэгдэх зардал нь 29 дүгээр хүснэгтэд тавигдах суурь нэгж үнэтэй ижил валютаар илэрхийлэгдсэн байх ёстой бөгөөд хэрэв өөр валютаар байвал хөрвүүлнэ.</p> <p>Тухайн бараанд ногдох зардлуудыг тооцохдоо нийт цэвэр жинд эзлэх хувиар бодно.</p>
33	Цэвэр жин (кг)	<p>Барааны цэвэр жинг кг-аар илэрхийлнэ.</p> <p>Бараатай хамт хэрэглэгчид очих буюу жижиглэн худалдаагаар хамт борлуулагдах баглаа боодлын жинг цэвэр жинд оруулж тооцно.</p> <p>Уялдуулсан системийн 2844, 2845 дугаар зүйлд хамаарах барааны цэвэр жинг эрх бүхий байгууллага /Цөмийн энергийн комиссын ажлын алба/-аар тодорхойлуулна.</p> <p>Гаалийн нэг мэдүүлгээр багцалж мэдүүлэх тохиолдолд тухайн мэдүүлэгт хамрагдах бүх тээврийн хэрэгсэлд ачигдсан барааны нийт цэвэр жинг бичнэ.</p>

34	Хасагдах зардал	<p>7 дугаар хүснэгтээс хамаарч импортын барааны хэлцлийн үнээс хасагдвал зохих Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 10.4 дэх хэсэгт заасан зардлуудын нийлбэрийг, экспортын барааны гаалийн үнээс хасагдвал зохих Монгол улсын хилийн гадна гарах зардлын дүнг бичнэ.</p> <p>Мэдүүлгийн 34 дүгээр хүснэгтэд хэлцлийн үнээс хасагдах зардлыг 7 дугаар хүснэгтэд бичигдсэн бараа нийлүүлэх нөхцөлөөс хамааран хэлцлийн үнэд шингэсэн тохиолдолд бичнэ. Хасагдах зардал нь 29 дүгээр хүснэгтэд тавигдах суурь нэгж үнэтэй ижил валютаар илэрхийлэгдсэн байх бөгөөд хэрэв өөр валютаар байвал хөрвүүлнэ.</p> <p>Нэг ачилтаар хэд хэдэн төрлийн барааг улсын хилээр оруулж ирсэн тохиолдолд хэлцлийн үнээс хасвал зохих зардлыг бараа болгонд хуваарилахдаа нийт ачилтын цэвэр жинд тухайн барааны ногдох жинг харьцуулах бөгөөд ийнхүү жинг харьцуулан зардлыг хуваарилах боломжгүй бол эзлэхүүн, эсхүл үнийн дүнг харгалзан зардлыг хуваарилж болно.</p>
35	Нэгжид ногдох зардал	30, 31, 32 дугаар хүснэгтүүдийн дүнг нэмж, түүнээс 34 дүгээр хүснэгтийн дүнг хасч, гарсан дүнг 26 дугаар хүснэгтийн ангиллын тоо хэмжээнд хувааж нэгжид ногдох зардлыг тооцно.
36	Гаалийн нэгж үнэ	29, 35 дугаар хүснэгтүүдийн нийлбэрийг бичнэ. Энэ нь 19 дүгээр хүснэгтэд бичигдсэн валюттай адил валютаар илэрхийлэгдэнэ.
37	Гаалийн нэгж үнэ (ам.дол)	36 дугаар хүснэгтэд тавигдах гаалийн нэгж үнийг ам.долларт хөрвүүлж бичнэ. 19 дүгээр хүснэгтийн валют нь ам.доллар бол 36, 37 дугаар хүснэгтүүдийн дүн ижил байна.
38	Арга	Гаалийн байгууллага мэдүүлэгчийн тодорхойлсон аргаас татгалзаж, бусад аргаар гаалийн үнийг тодорхойлсон бол үнэлгээний аргын кодыг бичнэ.
39	Мэдүүлэгчийн тодорхойлсон үнээс татгалзсан шалтгаан	Мэдүүлэгчийн тодорхойлсон гаалийн үнээс татгалзах болсон шалтгааныг кодоос сонгож тэмдэглэнэ.

40	Харьцуулсан баримт	<p>Гаалийн байгууллага гаалийн үнийг тодорхойлоход харьцуулан ашиглаж буй гаалийн мэдүүлгийн дугаар, олон улсын худалдааны мэдээлэл, бичиг баримтын нэр, дугаарыг бичнэ.</p> <p>ГТГТХ-ийн 11-р зүйл, 12-р зүйл болон 15.2.1 дэх заалтын дагуу гаалийн үнийг тодорхойлж байгаа тохиолдолд импортын барааны хэлцлийн үнийн аргаар үнэлэгдэж үнийн мэдээллийн баазад орсон мэдүүлгийн дугаарыг сонгоно.</p> <p>ГТГТХ-ийн 15.2.2.2, 15.2.2.5, 15.2.2.6 дахь заалтын дагуу гаалийн үнийг тодорхойлж байгаа тохиолдолд дараах дарааллын дагуу харьцуулсан баримтын мэдээллийг оруулна.</p> <p>Жишээ: ГТГТХ-15.2.2.5-03-ҮС1-1355. /Хуулийн заалт, тухайн гаалийн байгууллагын код, үнийн судалгааны товчилсон нэр, дугаар, тухайн судалгаа, мэдээлэл дэх тухайн барааны үнийн мэдээлэл бичигдсэн мөрийн дугаар/</p> <p>ГТГТХ-ийн 15.2.2.1, 15.2.2.3, 15.2.2.4 дэх заалтын дагуу гаалийн үнийг тодорхойлж байгаа тохиолдолд дараах дарааллын дагуу харьцуулсан баримтын мэдээллийг оруулна.</p> <p>Жишээ: ГТГТХ-15.2.2.4-02-www.j-ucar.com-2010.06.18 /Хуулийн заалт, тухайн гаалийн байгууллагын код, эх сурвалжийн нэр, тухайн эх сурвалжаас үнийн мэдээллийг авсан огноо/</p>
41	Сонгосон нэгж үнэ	Мэдүүлэгчийн тодорхойлсон аргаас бусад аргаар гаалийн үнийг тодорхойлоход сонгон авсан харьцуулах баримтын гаалийн нэгж үнийг бичнэ.
42	Залруулга	<p>Сонгон авсан нэгж үнэд нэмэгдэх залруулгыг (+) тэмдэгтэй, хасагдах залруулгыг (-) тэмдэгтэй тоогоор тус тус бичнэ.</p> <p>Тайлбар: Тээврийн төрөл, тээвэрлэх зайн ялгаа, тоо хэмжээ, худалдааны түвшин /үйлдвэрээс, бөөний, жижиглэнгийн г.м/ зэргээс хамаарч нэгж үнэд залруулга хийж болно.</p>
43	Гаалийн нэгж үнэ	Гаалийн байгууллагын тодорхойлсон барааны нэгж үнэ буюу 41 дүгээр хүснэгтийн дүн дээр 42 дугаар хүснэгтийн залруулгыг хийж ((+)тэмдэгтэй тоог нэмж, (-) тэмдэгтэй тоог хасч) гарсан дүнг бичнэ.
44	Квот	Эрх бүхий байгууллагаас тогтоосон барааны тоо хэмжээг эхний хэсэгт, тухайн ачилтын дараах үлдэгдэл тоо хэмжээг дараагийн хэсэгт бичнэ.
45	Статистик дүн	Гаалийн үнийг гаалийн байгууллага зөвшөөрсөн бол 37, зөвшөөрөөгүй бол гаалийн байгууллагын тодорхойлсон 43 дугаар хүснэгтийн гаалийн нэгж үнийг 26 дугаар хүснэгтийн ангиллын тоо хэмжээгээр үржүүлж статистик дүнг тооцно.
46	Статистик нийт дүн	Үндсэн болон нэмэлт мэдүүлгийн 45 дугаар хүснэгтүүдийн нийлбэр дүнг бичнэ. Тодотгох тоо хэмжээгээр барааны тоо хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд статистик дүн өөрчлөгдөж системээс бодогдоно.
47	Өмнөх горимын код	Өмнөх мэдүүлгийн гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг бичнэ.
48	Гаалийн баталгаат бүсийн код	Гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсийн кодыг бичнэ.

49	Татвар тооцооны тэмдэглэгээ	<p>Суурь үнэлгээний баганад гаалийн болон бусад татварыг тооцох төгрөгөөр илэрхийлэгдэх дүнг тавина.</p> <p>Гаалийн бүрдүүлэлтийн хураамжийн нийт дүнг “Хураамж” хэсэгт бичигднэ. “Нийт төлөх дүн” хүснэгтэд тухайн мэдүүлгийн бүх татварын дүн гарна.</p> <p>“Тариф” баганад тухайн бараанд ногдуулах тарифын хувь, хэмжээ; “Ногдуулсан татвар” баганад татварын ногдуулалт, “Төлсөн татвар” баганад татварын төлөлт, хураалт, “Чөлөөлсөн татвар” баганад чөлөөлсөн татвар, “Төлөлт код”, “Чөлөөлөлт код” хүснэгтэд энэ тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан татвар, хураамжийн төлөлт, татварын чөлөөлөлтийн кодын жагсаалтаас тохирох кодыг тус тус бичнэ.</p> <p>Нэмэлт мэдүүлгийн сүүлийн мөрөнд бүх бараанд ногдуулсан, төлсөн, чөлөөлсөн татварын дүн татварын төрлөөр харгалзах мөрөнд мэдүүлгийн програмаас бодогдож гарна.</p>
50	Өөрчлөгдөх татварын дүн	<p>Гаалийн мэдүүлгийн “F” хүснэгтэд бичсэн тодотгох тоо хэмжээг үндэслэн нэмж ногдуулах татварын дүнг (+), хасаж тооцох татварын дүнг (-) тэмдэгтэйгээр мэдүүлгийн програмаас бодогдож гарна.</p>
51	Төлбөл зохих татвар	<p>50 дугаар хүснэгтэд хорогдуулан, эсхүл нэмэгдүүлэн тооцох татвар бичигдсэн тохиолдолд 49 дүгээр хүснэгтийн “Нийт төлөх дүн”-гээс 50 дугаар хүснэгтийн дүн хасагдан, эсхүл нэмэгдэн мэдүүлгийн програмаас бодогдож гарна.</p>
52	Дагалдах баримтууд	<p>Барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтын нэр, тоо, дугаарыг харгалзах хэсэгт бүрэн бичнэ. Үүнд :</p> <ol style="list-style-type: none"> 1. ачааны манифест; 2. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх; 3. тээврийн баримт (ТИР карней бүхий барааны хувьд ТИР карнейн дугаарыг бичнэ); 4. тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз; 5. хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт; 6. Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг; 7. гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журамд заасан горимын шаардлагын дагуу бүрдүүлэх бичиг баримтууд.
A	Мэдүүлгийн № Он сар өдөр	<p>Энэ хэсэгт бүрдүүлэлт хийж байгаа гаалийн байгууллагын код бүхий мэдүүлгийн дугаар системд бүртгэгдэж, мэдүүлгийн програмаас олгогдоно. Мэдүүлсэн өдрийн огноо системээс олгогдоно.</p>

C	Хилийн гааль	<p>Бараанд гаалийн бүрдүүлэлт хийж байгаа хилийн гаалийн байгууллага тухайн горимд тохирох хяналтын тэмдгийг дарж, хяналт, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.</p> <p>Гүний гаалийн байгууллагад бүрдүүлэлт хийгдэх импортын бараанд хилийн гаалийн байгууллагын нэр, огноо мэдүүлгийн програмаас бичигдэнэ.</p> <p>Гүний гаалийн байгууллагад бүрдүүлэлт хийгдэж, гаалийн хяналтад илгээгдэх экспортын мэдүүлэгт эцсийн бүрдүүлэлт хийгдэх хилийн гаалийн байгууллагын нэрийг бичнэ.</p> <p>Хилийн гаалийн байгууллага эцсийн бүрдүүлэлт хийж, гаалийн хилээр гарсан огноог бичин, мэдүүлгийн хаалтыг хийнэ.</p>
D	<p>Гаалийн хяналт:</p> <p>-Гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээ</p> <p>-Гарын үсэг</p> <p>-Огноо</p> <p>Гаалийн шалгалт:</p> <p>-Гаалийн зорилгоор хийсэн битүүмжлэл, тэмдэглэгээ</p> <p>-Гарын үсэг</p> <p>-Огноо</p>	<p>Гаалийн хяналт хэсэгт барааг хяналтад авч гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийсэн арга, огноог бичиж гаалийн улсын байцаагч гарын үсэг зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарна.</p> <p>Гаалийн хяналтад авсан тэмдэглэгээ гэмтээгүй бол шалгасан гаалийн улсын байцаагч хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна. Гэмтсэн бол дахин хийсэн тэмдэглэгээг бичин, гарын үсэг зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.</p>
E	Гүний гаалийн тэмдэг	Бараанд гаалийн бүрдүүлэлт хийж байгаа гүний гаалийн байгууллага тухайн горимд тохирох хяналтын тэмдгийг дарж, хяналт, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.
F	Тодотгох тоо хэмжээ	Гаалийн мэдүүлгийг баталгаажуулсаны дараа болон гаалийн шалгалтын явцад бодит тоо хэмжээ нь мэдүүлсэн тоо хэмжээнээс дутсан тоо хэмжээг (-) тэмдэгтэй тоогоор, илүү гарсан тоо хэмжээг (+) тэмдэгтэй тоогоор, ангиллын хэмжих нэгжээр илэрхийлэн хяналт, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч мэдүүлгийн цахим бичлэгт бичиж, баталгаажуулна.
G	Тэмдэглэгээ	Гаалийн шалгалт дахин хийсэн албан тушаалтан шалгалт хийсэн огноог бичиж, гарын үсэг зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна. Системээс сонгогдсон хяналтын төлвөөс хамааран төлөв ногоон бол "G", улбар шар бол "O", Улаан бол "R" үсгээр тэмдэглэгдэнэ.

Гурав. Шилжүүлэн ачих, бараа устгах, бараа хүлээн авахаас татгалзах горимоор болон хялбарчилсан бүрдүүлэлт хийх үед гаалийн мэдүүлгийг нөхөн бичих

